



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 485

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн 2016-2017 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 774.0 сая (долоон зуун далан дөрвөн сая) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн 2016-2017 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Баярсайханд дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

2.2. Компанийн хөрөнгийг зохистой удирдах, авлагыг бууруулах, найдваргүй болох эрсдэлтэй авлагыг хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх;

2.3. Ашиглалтгүй байгаа үндсэн хөрөнгийг худалдах болон шилжүүлэх асуудлыг судалж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлэх;

2.4. Дуудлагын болон хөдөө ажлын шуурхай хэрэгцээнд ашиглаж байгаа автомашиныг шинэчлэх;

2.5. Шалгалтын тайланд дурдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах болон энэхүү тогтоолоор өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллах, биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б. ГАВАА

0002404

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 10 дугаар сарын 30-ний өдрийн
185 дугаар тогтоолын хавсралт

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн шалгалтаар
илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасныг зөрчиж тооцоо нийлээгүй, найдваргүй авлага үүсгэсэн	Гүйцэтгэх захирал, Санхүү бүтгэлийн хэлтэс	404,864,851.00	Мөнгөн хөрөнгийг зохистой удирдаж, авлагыг бууруулах арга хэмжээ авах, харилцагчтай үлдэгдэл төлбөр тооцоо нийлэх, найдваргүй авлагыг хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх /Цагдаагийн байгууллагад хандан эзэн холбогдогчийг тогтоолгох/
2	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлд заасныг зөрчиж худалдан авалт хийсэн	Гүйцэтгэх захирал, Хангамж, үйчилгээний алба, төндөрийн үнэлгээний хорооны дарга, гишүүд	369,114,561.00	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухай бүр цахим хэлбэрээр нээлттэй ил тод зарлах, төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авалт хийхгүй байх
Зөрчил, дутагдлын нийт дүн			773,979,412.00	